

Бүлэг, сэдэв: III. Эртний иргэншил
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Бидний өвөг дээдэс нүүдэлчид

НТӨ III мянганы эхэн үеэс Монгол орны уур амьсгал хуурайшиж, эрс тэс болж эхэлжээ. Энэ үеэс Монгол нутаг дахь эртний хүмүүс газар тариалан, суурин амьдралаас хөндийрч монгол орны цаг уур, байгаль, газар зүйн онцлогт тохирсон бэлчээрийн мал аж ахуй эрхлэн “нүүдэллэн” амьдрах болжээ. Ийнхүү нүүдлийн мал аж ахуйг голлон эрхэлдэг, морьтон нүүдэлчид нь “нүүдлийн иргэншил”-ийг үүсгэжээ.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.33-36 дэлгэрүүлж уншаарай.

1. Монгол орон уур амьсгал, байгаль, газар зүйн хувьд ямар онцлогтой байна вэ?

а. Жилийн дөрвөн улиралтай, эрс тэс уур амьсгалтай! гэх мэт.

б.

в.

2. Монгол нутагт амьдрагсад хэзээ, яагаад бэлчээрийн мал аж ахуй эрхлэх болсон бэ? Нүүдлийн иргэншлийн онцлог юу вэ?

.....
.....
.....

Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн дурсгал

1. Зүй тогтлыг ажиглан даалгаврыг гүйцэтгээрэй.

1 Дөрвөлжин булш

а Оршуулга ба тахилгын зориулалтай овоолго чулуун байгууламж.



2 Хиргисүүр

б Гонзгой урт чулууг засаж өнгөлөн гол төлөв буга дүрсэлнэ.



3 Буган хөшөө

в Эртний хүмүүс амьдрал ахуйгаа хад, чулуунд зураглаж үлдээсэн түүх.



4 Хадны зураг

г Мал амьтныг хийсвэрлэн “загварчилж” дүрсэлдэг урлагийн чиглэл.



5 Амьтны загварт урлаг

д Дөрвөлжин хэлбэрийн хашлага чулуу бүхий оршуулгын байгууламж.

Бүлэг, сэдэв: IV. Эртний улсууд
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Эртний хоёр мөрний улсууд

Тигр, Евфрат мөрөн нь Армяны уулсаас эх авч, урссаар Персийн буланд цутгадаг. Тигр, Евфрат мөрний хооронд орших өргөн уудам үржил шимт нутгийг “Месопотами” гэнэ. Армяны уулсын цас 3-4-р сард хайлахад хоёр мөрөн үерлэх бөгөөд үерийн усыг оршин суугчид аандаа амьдрал ахуйдаа хэрэглэж сурчээ. Энэ нутагт хүн төрөлхтний хамгийн эртний иргэншил болох “шүмрийн иргэншил” үүссэн ба НТӨ 3200 оны үеэс эхлэн “шүмер”-үүд 200 гаруй хот-улс байгуулснаас Ур, Урук, Лагаш, Ниппур түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Шүмерүүдийн дараа Аккад, Вавилон, Ассир, Шинэ Вавилоны төрт улсууд хоёр мөрний хөндийд ээлж дараалан байгуулагджээ.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.33-36 дэлгэрүүлж уншаарай.

1. Нэргүй газар зүйн зурагт дараах газар зүйн объект (юмс), шүмрийн хот-улсуудын нэрсийг зөв тэмдэглэнэ үү. **Тэмдэглэх газар зүйн юмс:** 1) Армяны уулс, 2) Тигр мөрөн, 3) Евфрат мөрөн, 4) Персийн булан. **Тэмдэглэх хот улсууд:** а) Ур, б) Урук, в) Лагаш, г) Ниппур. **Жишээ:** 1) Армяны уулсыг “хөх дугуй” дотор тоогоор (①), а) Ур хотыг “улаан дугуй” дотор үсгээр (a) тэмдэглэв.

Газар зүйн зураг 1.1



2. Хоёр мөрөн хаанаас эх авч, хаана цутгадаг вэ?

.....
.....
.....


3. Эртний хоёр мөрний ард түмэн үерийн усыг ахуй амьдралдаа хэрхэн хэрэглэдэг байсан бэ?

.....
.....
.....

4. Эртний хоёр мөрөн нь өнөөгийн ямар улсын нутгийг ихэвчлэн хамарч байна вэ?

.....

5. Хоёр мөрний хөндийд ээлж дараалан оршин тогтносон улсуудыг он тооллын шугамд тэмдэглээрэй. **Тэмдэглэх улсууд:** Аккад, Вавилон, Ассир, Шинэ Вавилон.



6. Түлхүүр үгсийг ашиглан “Эртний хоёр мөрний улсуудын соёл” сэдэвт эх зохиогоорой. Түлхүүр үгс: Шаантаг бичиг, Зигурат, Хаммурапи хааны хууль.

.....
.....
.....
.....
.....

Бүлэг, сэдэв: IV. Эртний улсууд
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Эртний Египет

Эртний египетчүүд Нил мөрний дагуу суурин, хот байгуулж, газар тариалан эрхлэн амьдардаг байв. Нил мөрөн дорнод Африкийн тэгш өндөрлөгөөс эх авч, Газар дундын тэнгист цутгадаг. Нил мөрний эх авч буй өндөрлөг газрыг “дээд Египет”, олон салаа болж Газар дундын тэнгист цутгаж буй нам хэсгийг “доод Египет” гэнэ. НТӨ IV мянганд дээд, доод Египетэд хот-улсууд байгуулагджээ. НТӨ 3000 оны орчим хоёр Египетийг Менэс (Нармер) нэгтгэн захирч анхны “фараон” болжээ. Эртний Египетийн түүхийг I) Эртний хаанчлалын үе (НТӨ 2900-2060), II) Дундад хаанчлалын үе (НТӨ 2060-1580), III) Шинэ хаанчлалын үе (НТӨ 1580-1090) гэсэн 3 үед хуваан үзэж болно.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.44-49 дэлгэрүүлж уншаарай.

1. Нэргүй газар зүйн зурагт дараах газар зүйн юмсыг зөв тэмдэглэнэ үү. **Тэмдэглэх газар зүйн юмс:** 1) Нил мөрөн, 2) дээд Египет, 3) доод Египет. Жишээ: 1) Нил мөрөнг тэмдэглэв.

Газар зүйн зураг 1.2



2. Нил мөрөн хаанаас эх авч, хаана цутгаж байна вэ?

.....
.....

3. Нил мөрний хөндийн байгаль, газар зүйн онцлог ямар байна вэ?

.....
.....

4. Эртний египетчүүд ямар ямар аж ахуй эрхлэн хэрхэн амьдарч байсан бэ?

.....
.....

5. Он тооллын шугам дахь эртний египетчүүдийн түүхийн үечлэлийг гүйцээгээрэй.



6. Үгийн сүлжээг бөглөж эртний египетчүүдийн түүхийн мэдлэгээ бататгаарай.

Босоогоор

1. Эртний египетчүүдийн оршуулга ба тахилын байгууламж
2. Эртний египетчүүд хэмээх цаасан дээр бичдэг байжээ
3. Эртний хаанчлалын үеийн алдартай фараонуудын нэг
4. Эртний хаанчлалын үеийн алдартай фараонуудын нэг
5. Монголчууд египетчүүдийг нэрлэх нэр
6. Дунд хаанчлалын үеийн Египетийн нийслэл

Хөндлөнгөөр

1. Дээд, доод египетчүүдийг нэгтгэсэн анхны фараон
2. Эртний египетчүүдийн бичиг үсгийг гэнэ
3. Эртний египетчүүдийн “хүн толгойт, арслангийн дүрт” домгийн амьтан
4. Пирамидад фараоныг занданшуулан болгож оршуулдаг
5. Дунд хаанчлалын үед египетчүүдийг довтолсон нүүдэлчид
6. Египетээр “хаан” гэсэн утгатай үг



Үгийн сүлжээ 1.1



Бүлэг, сэдэв: IV. Эртний улсууд
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Эртний Энэтхэг

НТӨ 7000 оны үеэс Инд мөрний хөндийд хүмүүс усалгаат тариалан эрхлэж, НТӨ 3000 оноос суурьшин амьдрах болжээ. Инд мөрөн Хиндукуш, Гималайн нуруунаас эх авч Арабын тэнгист цутгадаг. Инд мөрний анхны иргэншлийг “дравидууд” үүсгэжээ. Инд мөрний хөндийд байгуулагдсан анхны хотуудаас хамгийн том нь *Хараппа*, *Мохенжо-даро* байв. Эртний Энэтхэгийн түүхийг I) Эртний үе (НТӨ 2300-1750), II) Ведийн үе (НТӨ 1500-500), III) Буддын үе (*Маурын эзэнт гүрэн НТӨ 321- НТ 185*) гэсэн 3 үед хуваан үзэж болно.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.52-57 дэлгэрүүлж уншаарай.

1. Нэргүй газар зүйн зурагт дараах газар зүйн юмс, хотуудыг зөв тэмдэглэнэ үү.
Тэмдэглэх газар зүйн юмс, хот: 1) Инд мөрөн, 2) Мохенжо-даро хот, 3) Хараппа хот. Жишээ: 1) Инд мөрөнг тэмдэглэв.

Газар зүйн зүйн зураг 1.3



2. Инд, Ганга мөрөн хаанаас эх авч, хаана цутгадаг вэ?

.....
.....

3. Энэтхэгийн хойгийн байгаль, газар зүйн онцлог ямар байна вэ?

.....
.....

4. Эртний энэтхэгчүүд ямар аж ахуй эрхлэж, хэрхэн амьдарч байсан бэ?

.....
.....

5. Түлхүүр үгсийг тайлбарлах замаар эртний Энэтхэгийн түүхийг үечлэлийн дагуу бүтээгээрэй.

I) Эртний үе (НТӨ 2300-1750 он) Дравид? Энэтхэгийн хойгийн уугуул иргэд юм! гэх мэт.

Хараппа, Мохенжо-даро?

Аричууд?

Кастын тогтолцоо гэж юу вэ? Давхарга бүрийн эрх үүргийг бичээрэй.

- Брахман
- Кшатри
- Вайши
- Шудра

Веда?

Хинду шашин?

Индра?

Убанишид?

Сидхарта Гаутама?

Ашока?

Маурын эзэнт гүрэн?

II) Ведийн үе
III) Маурын эзэнт гүрэн

Бүлэг, сэдэв: IV. Эртний улсууд
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг


Эртний Хятад

НТӨ IV мянганы үеэс Шар мөрний хөндийд анхны суурингууд байгуулагдаж, улаан буудай, шар будааны усалгаат тариалан эрхэлдэг байжээ. Шар мөрөн нь Түвэдийн тэгш өндөрлөгөөс эх авч, Шар тэнгист цутгадаг. НТӨ 2100 оноос Шар мөрний хөвөөнд анхлан Ся улс (НТӨ 2100-1776) байгуулагджээ. Ся улсын дараа Шан (НТӨ 1776-1112), Жоу (НТӨ 1112-256), Цинь (НТӨ 221-206), Хан (НТӨ 206- НТ 220) улсууд ээлж дараалан оршин тогтнож байжээ.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.51-58 дэлгэрүүлж уншаарай.

1. Нэргүй газар зүйн зурагт дараах газар зүйн юмсыг зөв тэмдэглэнэ үү. **Тэмдэглэх газар зүйн юмс:** 1) Шар мөрөн, 2) Шар тэнгис.

Газрын зүйн зураг 1.2



2. Шар мөрөн хаанаас эх авч, хаана цутгаж байна вэ?

.....
.....

3. Шар мөрний хөндийн байгаль, газар зүйн онцлог ямар байна вэ?

.....
.....

4. Эртний Хятадууд ямар аж ахуй эрхлэн хэрхэн амьдарч байсан бэ?

.....
.....

5. Эртний Хятадын төр улсуудын оршин тогтносон он цаг, аж ахуй, соёлын ололт дэвшлүүдийг хүснэгтэд нөхөж бичээрэй.

Хүснэгт 1.1

№	Улсууд	Он цаг	Аж ахуй, соёлын ололт
1	Ся улс	Усалгаат тариалан эрхлэх болов! гэх мэт.
2	Шан улс
3	Жоу улс
4	Цинь улс	Анхны нээдмэл төр улс. Цагаан хэрэм барив!
5	Хан улс

6. Эхлээд мэдээллийг уншиж, дараа нь асуултуудад хариулаарай.

Мэргийн бичиг: Шан улсын хаад үхрийн далны яс, яст мэлхийн хуяг дээр “сайн”, “муу” хүслээ бичиж, мэргэ төлгө буулгадаг байв. Ингэхдээ бичигтэй ясаа галд шатааж, үүссэн цууралт хагаралтыг хараад ирээдүйг тайлбарладаг байжээ. Мэргийн бичиг бол ханз үсгийн хамгийн эртний дурсгал болой.



Яст мэлхийн хуяг дээр сийлсэн мэргийн бичиг

а) Мэргийн бичиг нь эх сурвалжийн ямар төрөлд багтах вэ?

.....

б) Мэргийн бичгийн холбогдох он цагийг тодорхойлоорой.

.....

в) Мэргийн бичгийг юу, юун дээр бичих вэ? Ямар зорилгоор бичсэн бэ?

.....
.....

Бүлэг, сэдэв: IV. Эртний улсууд
 Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
 Дууссан: он ... сар ... өдөр цаг


Эртний Грек

Балканы хойгийн өмнөд төгсгөл, Эгейн тэнгисийн арлуудад Грекийн иргэншил үүсчээ. Грекийн газар нутаг нь уулархаг, олон жижиг хөндийд хуваагдсан ч жилийн турш нартай, чийглэг уур амьсгалтай тул грекчүүд усан үзэм, чидун жимс, арвай тариална. НТӨ VIII-VI зууны орчим байгаль газар зүйн онцлогоос улбаалж Грект эзэнт гүрэн биш олон тусгаар “хот улс”-ууд байгуулагджээ. Грекийн хот улсуудаас цэрэг, эдийн засгийн хувьд хамгийн хүчирхэг нь Спарт, Афин байв.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.60-61 дэлгэрүүлж уншаарай.

1. Нэргүй газар зүйн зурагт дараах газар зүйн юмс, хотуудыг зөв тэмдэглэнэ үү. **Тэмдэглэх газар зүйн юмс, хот:** 1) Эгейн тэнгис 2) Балканы хойг, 3) Афин хот, 4) Пелопоннесийн Спарт хот. **Жишээ:** 1) Эгейн тэнгисийг тэмдэглэв.

Газар зүйн зүйн зураг 1.4



2. Эртний Грекийн байгаль, газар зүйн онцлог ямар байна вэ?

.....

3. Эртний грекчүүд ямар аж ахуй эрхэлж байсан бэ?

.....

4. Афин, Спарт хот-улсуудын ялгаатай талуудыг шинжлээрэй.

Хүснэгт 1.2

	Афин хот-улс	Спарт хот-улс
1. Төрийн байгуулал
2. Нийгмийн давхарга
3. Эрхлэх аж ахуй
4. Хүмүүжлийн тогтолцоо

5. Эртний Грек бол домгийн (миф) эх орон билээ. Домгоос сэдэвлэн грекчүүд яруу найраг, инээдмийн ба эмгэнэлт жүжгийн зохиолууд туурвиж, задгай театрт тоглодог байв. Эртний Грекийн яруу найргийн аль зохиолд грекчүүдийн Трой хот руу хийсэн аян дайны тухай өгүүлдэг вэ? Зохиогч нь хэн бэ?

.....

6. Зүй тогтлыг ажиглан үгийн сүлжээг бөглөөрэй.

Үгийн сүлжээ 1.2

1. Грекийн задгай театр

2. Аянгын бурхан

3. Дайны бурхан

4. Урлагийг ивээгч, нарны бурхан

5. НТӨ 776 он

6. Тэнгис далайн бурхан

Бүлэг, сэдэв: IV. Эртний улсууд
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Эртний Ром

Газар дундын тэнгисийн дунд Аппениний хойгийн төв хэсэгт Ромын иргэншил үүсчээ. Эртний Ромын иргэншлийн төв Ром хот нь НТӨ 753 онд далайн эргээс холгүй Тибер голын хөвөөнд байгуулагджээ. Ром эхэндээ тариачин, малчдын жижиг хаант улс байсан бол НТӨ 510 оны орчим Бүгд Найрамдах Улс болжээ.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.60-67 дэлгэрүүлж уншаарай.

1. Нэргүй газар зүйн зурагт дараах газар зүйн юмс, хотыг зөв тэмдэглэнэ үү. **Тэмдэглэх газар зүйн юмс, хот:** 1) Аппениний хойг, 2) Адриатын тэнгис, 3) Сицили арал, 4) Ром хот.

Газар зүйн зүйн зураг 1.4



2. Эртний Ромын байгаль, газар зүйн онцлог ямар байна вэ?

.....
.....

3. Эртний ромчууд ямар аж ахуй эрхэлж байсан бэ?

.....
.....



Капитолийн өлөгчин чоно

4. Сурах бичгийн 60-р талын Ром хот үүссэн тухай домгийг зөв дараалалд оруулж, хөшөөтэй хэрхэн холбогдож буйг тайлбарлаарай.

.....
.....

5. Ромын хаант улс, Ромын Бүгд найрамдах улсын ялгаатай талуудыг шинжлээрэй.

	Ромын хаант улс	Ромын Бүгд Найрамдах улс
Төрийн байгуулал
Нийгмийн давхарга	- Язгууртнууд (баян патриц, плебей) - Морьтонгууд (худалдаачид, түшмэд) - Плебс (борчууд) - Боол (гэрийн боол, мэсчин боол буюу гладиатор)

НТӨ 74 онд Ромд мэсчин боол Спартакар удирдуулсан боолчуудын бослого дэгдэж, НТӨ 71 онд дарагджээ.

6. Он тооллын шугамд а) Ром хот байгуулагдсан он, Ромын Бүгд Найрамдах улс байгуулагдсан он, Пунийн дайн эхэлсэн он, Юлий Цезарь диктатор болсон оныг тэмдэглээрэй. б) Ром хот одоогоос хэдэн жилийн өмнө байгуулагдсан бэ?

Дасгал ажиллах хэсэг:



7. Он цаг, түлхүүр үгсийг ашиглаж Ромын эзэнт гүрний түүхийг бүтээгээрэй. **Он цаг:** (НТӨ 27-НТ 180 он), 324 он, 476 он. **Түлхүүр үгс:** Ромын эзэнт гүрэн, Октавиан (Август хаан), Шинэ Ром, Баруун Ромын эзэнт улс, Зүүн Ромын эзэнт улс, Константинополь, Ромул Август.

.....
.....
.....
.....



Бүлэг, сэдэв: IV. Эртний улсууд
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Нүүдэлчдийн анхны төрт улс Хүннү гүрэн

Ази тивийн төвд, далай тэнгисээс алслагдмал эх газрын хуурай, эрс тэс уур амьсгалтай, өндөр уулс, хээр тал, говь цөл хосолсон өргөн уудам нутагт НТӨ 209 онд нүүдэлчдийн анхны төрт улс Хүннү байгуулагджээ. Хүннүчүүдийн угсаа гарал нь Монголын хүрлийн үе, түрүү төмрийн үеийн (НТӨ III мянган-НТӨ III зуун) “дөрвөлжин булш, хиргисүүр, буган хөшөө”-ний соёлын эзэдтэй холбогддог билээ.
У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.69-73 дэлгэрүүлж уншаарай.


1. Газар зүйн зургийг ашиглаж Хүннү гүрний газар нутгийн дөрвөн захын цэгийг нэрлээрэй. Жишээ: Зүүн захын цэг “Солонгосын хойг”-ийг тэмдэглэв.
Газар зүйн зүйн зураг 1.5



2. Хүннүгийн байгаль, газар зүйн онцлог тэдний аж амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?

.....
.....

3. Он тооллын шугамд, а) Хүннү гүрэн байгуулагдсан ба задарсан он цагийг тэмдэглээрэй. б) Хүннү гүрэн хэдэн жил оршин тогтносныг тооцоолоорой.



4. Эх сурвалжийн мэдээг уншиж, дараах асуултад хариулаарай.

Сыма Цяний “Түүхэн тэмдэглэл”-ийн 110-р бүлэг “Хүннүгийн шастир”-аас: Модунийг шаньюй болмоги, хөрш Дунху нар шахалт үзүүлжээ. Тэд эхлээд хурдан хүлэг морио өгөхийг, дараа нь хайртай хатнаа өгөхийг шаардав. Модунь нэхсэн бүхнийг өгсөн байна. Эцэст нь Дунху нар хилийн зааг дахь нутгийг өгөхийг шаарджээ. Түшмэдүүд нь “хүн нутагладаггүй тэр газрыг өгсөн ч болно!” гэхэд Модунь – “газар бол төр улсын үндэс” хэмээж, их цэргээ довтолгон Дунхуг эзэлжээ.

- Эх сурвалжид юун тухай өгүүлж байна вэ? Модунь яагаад Дунху нарын сүүлийн хүсэлтийг биелүүлээгүй вэ?

.....
.....

5. Түлхүүр үгсийг ашиглан “Хүннүгээс бидэнд уламжлан ирсэн өв соёл” сэдэвт эх зохиогоорой. Түлхүүр үгс: Эрийн гурван наадам, Цагаан сарын баяр, Уртын дуу, Амьтны загварт урлаг.

.....
.....
.....

Бүлэг, сэдэв: IV. Эртний улсууд
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Монгол угсааны Сяньби, Жужан улс

Сяньби (156-235 он), Жужан улс (330-555 он) нь Хүннүг залган гарч ирсэн Монгол угсааны улсууд тул Хүннүгийн адил бэлчээрийн мал аж ахуй голлон эрхлэх ба хавсарга байдлаар газар тариалан эрхлэн жилийн дөрвөн улиралд нүүдэллэн амьдардаг байв. Сяньби бол Дунхугийн удам, монгол хэлтэн нүүдэлчид билээ. Харин Жужан нь Сяньби улс 235 онд олон хэсэгт задарсны дараа монгол нутагт төвлөрч байсан Сяньби угсааны улс юм. Хүннү, Сяньби нарыг эртний монголчууд, Жужаныг язгуур монголчууд гэнэ.


У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.76-79 дэлгэрүүлж уншаарай.

1. Сяньби, Жужан улсын байгаль, газар зүйн онцлог тэдний ахуй амьдралд хэрхэн нөлөөлсөн бэ?

.....
.....
.....

2. Он тооллын шугамд Сяньби, Жужан улс оршин тогтносон он цагийг тэмдэглээрэй.

Дасгал ажиллах хэсэг:



3. Эртний хятад сурвалжид “Тэдний (Сяньби нарын) зэвсгийн хурц, морины хурдан нь Хүннү нарынхаас нэн хэтийдсэн” гэж тэмдэглэжээ. Яагаад Сяньби нарын тухай бичихдээ хүннүчүүдтэй харьцуулсан бэ?

.....
.....

4. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутаг Цамбагарав уулын хаданд буй хадны зургийг ажиглаж асуултад хариулаарай.

Хадны зураг 1.1



а) Хүннү, Сяньби, Жужан улсын алинд хамаарах вэ?

.....

б) Хадны зурагт юуг дүрсэлсэн байна вэ?

.....

в) Уг хадны зургаас тухайн улсын цэргийн талаар ямар мэдээллийг олж авсан бэ?

.....

5. Сяньби, Жужан улсын тухай сурвалжийн мэдээг уншиж, асуултад хариулаарай.

“Хожуу Хан улсын судар”-т: “Хүлэг морь унах, харвах намнахдаа гарамгай, ан гөрөө хийж аж төрнө. Өвс усны сайныг дагаж мал маллана. Орон сууц нь тогтворгүй, эсгий дугуй майхнаар гэр хийж, дорно зүг хандуулан барина. Мах идэж, цэгээ уун, арьс ноосоор хувцас хийнэ”

- Сяньби, Жужан улсуудад Хүннү болон өнөөгийн монголчуудтай аж ахуй, соёлын хувьд адил төстэй зүйлүүд юу юу байгааг тоочин нэрлээрэй.

.....
.....
.....
.....

Бүлэг, сэдэв: IV. Эртний улсууд
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

Монгол нутаг дахь Түрэг угсааны улсууд


Түрэг аймгууд нь Жужан улсын харьяанд Алтай нурууны орчим нутаглаж төмрөөр алба барьдаг байв. Тэд 552 онд Жужаны эсрэг бослого (Төмөрчдийн бослого) гаргаж, Жужан улсыг мөхөөсөн билээ. Ийнхүү Түрэг (555-745 он), Уйгур (745-840 он), Киргиз (840-842 он) гэсэн түрэг угсааны улсууд ээлж дараалан монгол нутагт оршин тогтнож байжээ.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.80-81 дэлгэрүүлж уншаарай.

1. Түрэг, Уйгур улсын газар зүйн зураг болон түүхэн дурсгалуудын зургийг харьцуулж даалгавруудыг ажиллаарай.

Газар зүйн зураг 1.1

Газар зүйн зураг 1.2



Орхон голын хөндийгөөс 1889 онд Оросын эрдэмтэд үл мэдэгдэх бичээс бүхий аварга том хөшөө олжээ. Энэ бичээсийг “үл мэдэгдэх” буюу “Руни” бичиг гэж нэрлэсэн байна. Энэхүү бичээс нь VIII зууны үед эртний Түрэг хэлээр бичигджээ.

Билэг хааны гэрэлт хөшөө (сэргээсэн байдлаар)



Уйгурын хүн чулуу

а) Түрэг угсааны улсууд хаана улсаа байгуулж байсан бэ?


.....
.....
.....

б) Яагаад монголчуудтай угсаа гарлын хамааралгүй эртний түрэгүүдийн түүх соёлын дурсгал, хот суурин монгол нутгаас илэрч олддоод байна вэ?

.....
.....

2. Он тооллын шугамд: а) Түрэг, Уйгур, Киргиз улс оршин тогтносон он цагийг тэмдэглээрэй. б) Түрэг угсааны улсууд хэдээс хэддүгээр зуунд монгол нутагт ноёрхсон бэ?

Дасгал ажиллах хэсэг:



3. Монгол нутагт түрэг угсааны улсууд ноёрхож байсан энэ үед Монголын овог, аймгууд хаана нутаглаж, хэрхэн аж төрж байв? Таамаглалаа дэвшүүлээрэй.

.....
.....

Бүлэг, сэдэв: IV. Эртний улсууд
Сурагчийн овог, нэр:

Эхэлсэн: он ... сар ... өдөр цаг
Дууссан: он ... сар ... өдөр цаг

VI-X зууны Монголын аймаг, улсууд

VI зуунд жужанчууд Түрэгт ялагдан гурав хуваагджээ. I) Жужанчуудын дийлэнх нь эх нутагтаа үлдэж Түрэг, Уйгур улсуудад захирагдсан байна. II) Жужанчуудын зарим хэсэг нутгийнхаа зүүн тал руу шахагдан Хөлөн ба Буйр нуурын саваар нутаглах болжээ. III) Жужаны ноёлох Нукуз, Хиан овгууд түрэгээс дайжин Их Хянганы нуруунд байх Эргүнэ гүн хэмээх газар очиж нутагласан байна.

У.Туяа нар. Түүх VI. УБ., 2019. т.82-83 дэлгэрүүлж уншаарай.

1. Нэргүй газар зүйн зурагт дараах газар зүйн юмсыг зөв тэмдэглэнэ үү. **Тэмдэглэх газар зүйн юмс:** 1) Хянганы нуруу 2) Буйр нуур 3) Хөлөн нуур 4) Эргүнэ гүн. **Жишээ:** 1) Хянганы нурууг тэмдэглэв.

Газар зүйн зүйн зураг 1.6



а. Түрэгт ялагдсан жужанчууд VI-X зуунд хаана нутаглаж, хэрхэн аж төрж байв?

.....
.....
.....
.....

2. Эргүнэ гүнгийн домгийг уншиж, асуултад хариулаарай.

Эрт цагт Монгол гэж нэрлэгдэж байсан аймаг бусад Түрэг аймагтай хямралдан, дайн тулаанаар шувтарчээ. Бусад аймаг нь Монголыг дийлээд хоёр эрэгтэй, хоёр эмзэгтэйгээс илүү хүн үлдээлгүйгээр хяджээ. Эдгээр хоёр өрх дайснаас айхдаа хүршгүй газар зугтан очжээ. Уулс ойгоор хүрээлэгдсэн тэр нутагт ганц нарийн жимээр явж хүрчээ. Дотроо өвс, ус элбэгтэй тэр нутгийг Эргүнэ гүн гэж нэрлэдэг.

(Монголын Ил хаант улсын төрийн сайд Рашид Ад Дин-ий 1304 онд туурвисан Судрын чуулган)

а) “Судрын чуулган”-ы зохиогчийн тухай юу бидэнд тодорхой байна вэ?

.....

б) Эх сурвалжид гарч буй үйл явдал хэдий үед холбогдох вэ?

.....

в) Эх сурвалжид Эргүнэ гүн хэмээх газрын тухай юу өгүүлж байна вэ?

.....
.....

г) “Монголын нууц товчоо”-нд буй “Чингис хааны язгуур. Дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ Чоно ажгуу. Гэргий нь Хоо ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж...” гэсэн энэ мэдээ Эргүнэ гүний домогтой хэрхэн холбогдоно гэж бодож байна вэ? Сурах бичгийн мэдээллийг ашиглаарай.

.....
.....
.....

Нэмэлт мэдээлэл: Түрэгт ялагдсан жужанчуудын зарим хэсэг Эргүнэ гүнд 400-аад жил сууж, өсч өнөржин олон аймаг болов. Тэд өөрсдийгөө “Монгол” хэмээн нэрлэдэг байжээ. “Монгол” гэх нэр нь Жужаны түүхэнд тэмдэглэгдсэн анхны толгойлогч Мугулюй-н (мухар толгойт) нэрээс үүдэлтэй ажээ. Түрэг, Уйгур улсын бүрэлдэхүүнд захирагдаж байсан жужанчуудыг тэд “Гучин Татар”, “Есөн Татар” хэмээн хөшөөний бичээсүүдээ тэмдэглэсэн байдаг. Татар хэмээх нэр нь Жужаны “Датань” хааны нэрээс үүссэн байна.